



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 17 өдөр

Дугаар А/102

Хужирт сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн А/214 дүгээр тушаалаар батлагдсан “Коронавируст халдвар (Ковид-19)-ын батлагдсан болон сэжигтэй цогцсыг оршуулахад баримтлах түр журам”, Улсын Онцгой комиссын шуурхай штабын даргын 2021 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн “Коронавируст халдвар (Ковид-19)-ын батлагдсан болон сэжигтэй цогцсыг оршуулах үйл ажиллагаанд мөрдөх түр заавар”-ын 2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Коронавируст халдвар (Ковид-19)-ын батлагдсан цогцсыг оршуулахад хяналт тавих, халдваргүйжүүлэлт хийх, гүйцэтгэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Дэмбэрэл - Засаг дарагын орлогч

Гишүүд: Х.Түмэнбаяр - Цагдаагийн тасгийн дарга, дэд
Хурандаа

Б.Пагамдулам – 1 дүгээр багийн Засаг дарга

О.Амгалан - 5 дугаар багийн эмч

Б.Бямбасүрэн - Байгаль орчны Хяналтын улсын
байцаагч

Д.Баянсан - Эрэн хайх, аврах бүлгийн дарга

С.Цэндхорол - Эрүүл мэндийн төвийн сувилагч

2. Оршуулах үйл ажиллагааг түр журам, түр зааврын дагуу зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг ажлын хэсэг (Б.Дэмбэрэл) даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ